



**НОМУУН БЭХИ АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо  
Энх тайваны өргөн чөлөө, Гео төв 508 тоот  
Утас: 77112488, 99096345, 94006880  
И-мэйл: nomuunbekhi@gmail.com

**“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН**

**УДИРДЛАГАД**

2023 оны 02 сарын 27 өдөр

№ ДГ-21-23

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

### **Дүгнэлт**

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тайлангийн тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаа, зөрчилгүй үнэн зөв толилуулсан байна.

### **Аудитын дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт найдаж байна.

### **Санхүүгийн тайлангийн талаархи компаний Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Сангийн яамнаас гаргасан холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх



мөрдөх, нягтлан бодох хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хүлээнэ. Засаглах удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын процесст хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг.

АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийлэлийг байнга илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар зөвлөмж өгч ажиллана. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба материаллаг алдаа нь хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэл болж болзошгүй гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

“НОМУУН БЭХИ АУДИТ” ХХК-ЫН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.УНДРАХ

2023 оны 02 сарын 27

